



2019 оны 06 дугаар сарын 19
№24 /1077/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Хэмжил зүйн тухай
/Шинэчилсэн найруулга/**

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын Их
Хурлын чуулганы хуралдааны
дэгийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Төрөөс барилгын салбарын
талаар баримтлах бодлого
батлах тухай**

ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

214.	Хэмжил зүйн тухай /Шинэчилсэн найруулга/	869
215.	Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	883
216.	Хэмжил зүйн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөх журмын тухай	883
217.	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	884
218.	Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай	884
219.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай	885
220.	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	885
221.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	886

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

222.	Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 70	897
------	---	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилго нь хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд хэмжил зүйн бодлогоор дэмжлэг



үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоож, хэмжил зүйн чиглэлээр хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хэмжил зүйн хууль тогтоомж

2.1.Хэмжил зүйн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“хэмжил” гэж хэмжигдэхүүний тоон утгыг тодорхойлох үйл ажиллагааг;

3.1.2.“хэмжлийн нэгж” гэж хэмжил гүйцэтгэхэд жишиг болгон сонгож авсан нэгж хэмжигдэхүүнийг;

3.1.3.“хэмжлийн эталон” гэж хэмжлийн нэгж, түүний тодорхой утгыг тогтоох, бий болгох, хадгалах, хуулбарлах, харьцуулах замаар бусад хэмжих хэрэгсэлд дамжуулах зориулалттай хэмжих хэрэгслийг;

3.1.4.“улсын эталон” гэж үндэсний хэмжээнд хэрэглэх хамгийн өндөр нарийвчлалтай хэмжлийн эталоныг;

3.1.5.“хэмжих хэрэгсэл” гэж хэмжил гүйцэтгэхэд ашиглаж байгаа хэмжил зүйн тогтоосон үзүүлэлт бүхий техник хэрэгслийг;

3.1.6.“нэгж дамжуулалт” гэж шалгалт тохируулгын зохих шатлалаар хэмжлийн эталонтой харьцуулсан хэмжлийн үр дүнгийн үзүүлэлтийг;

3.1.7.“хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга” гэж хэмжих хэрэгслийн заалтыг тодорхой нөхцөлд хэмжлийн эталоны утгатай харьцуулж, хэмжлийн үр дүнг тогтоох үйл ажиллагааг;

3.1.8.“стандартчилсан загвар” гэж хэмжил гүйцэтгэх, бодис, материалын хэвийн үзүүлэлтийг шалгах зориулалтаар зохион бүтээсэн, найрлага шинж чанар нь өөрчлөгдөхгүй нэг төрлийн жишиг бодис, материалыг;

¹Монгол Улсын Үндсэн хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.



3.1.9.“хэмжил гүйцэтгэх аргачлал” гэж хэмжил гүйцэтгэх үндэслэл болгосон физикийн зарчим, тухайн хэмжих хэрэгслийг ашиглах нөхцөл, арга зүйг тогтоосон баримт бичгийг;

3.1.10.“хэмжил зүйн мэргэжлийн байгууллага” гэж тодорхой салбарт хэмжил зүйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий хуулийн этгээдийг;

3.1.11.“хэмжих хэрэгслийн загварын туршилт” гэж хэмжих хэрэгслийн загварыг эрх бүхий байгууллагаас туршиж, үр дүнг тогтоох тохирлын үнэлгээний үйл ажиллагааг;

3.1.12.“хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт” гэж хэмжих хэрэгсэл нь тогтоосон шаардлагад нийцэж байгаа эсэхийг эрх бүхий байгууллагаас шалган нотлох тохирлын үнэлгээний үйл ажиллагааг;

3.1.13.“савласан бүтээгдэхүүн” гэж бүтээгдэхүүний тоон хэмжээг урьдчилан тогтоож, өөрчлөх боломжгүйгээр битүүмжилсэн бараа материалыг.

3.2.Энэ хуулийн 3.1-д зааснаас бусад нэр томьёог Хэмжил зүйн болон Стандартчиллын олон улсын байгууллагаас баталсан нэр томьёоны тодорхойлолт, тайлбар, толь бичгийн стандартад заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХЭМЖЛИЙН НЭГЖ, ХЭМЖЛИЙН ЭТАЛОН, НЭГЖ ДАМЖУУЛАЛТ

4 дүгээр зүйл.Хэмжлийн нэгж

4.1.Монгол Улсад Олон улсын жин хэмжүүрийн Ерөнхий бага хурлаас тогтоосон олон улсын системийн хэмжлийн нэгжийг хэрэглэнэ.

4.2.Энэ хуулийн 4.1-д зааснаас бусад хэмжлийн нэгжийг Засгийн газраас тогтоосноор олон улсын системийн хэмжлийн нэгжтэй нэгэн адил хэрэглэж болно.

4.3.Хэмжлийн нэгжийн нэр, тэмдэглэгээ болон тэдгээрийг бичих, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

4.4.Экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүний чанар, техникийн үзүүлэлтийг захиалагчийн хүсэлтээр энэ хуулийн 4.1-д зааснаас өөр хэмжлийн нэгжээр илэрхийлж болно.



5 дугаар зүйл.Хэмжлийн эталон, стандартчилсан загвар

5.1.Улсын эталоныг Засгийн газар, стандартчилсан загварыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

5.2.Улсын эталон төрийн хамгаалалтад байна.

5.3.Батлагдсан стандартчилсан загварыг хэмжлийн эталоны нэгэн адил хэрэглэнэ.

5.4.Улсын эталон, батлагдсан стандартчилсан загварыг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.

6 дугаар зүйл.Нэгж дамжуулалт

6.1.Улсын эталон, стандартчилсан загварын нэгж нь энэ хуулийн 4.1-д заасан хэмжлийн нэгжтэй нийцсэн байна.

6.2.Улсын эталон, стандартчилсан загварын нэгж дамжуулалтыг олон улсын, эсхүл гадаад орны хүлээн зөвшөөрөгдсөн хэмжлийн эталонтой харьцуулах замаар хангана.

6.3.Ажлын эталонд нэгж дамжуулалтыг улсын эталоноос, эсхүл гадаад орны хүлээн зөвшөөрсөн дээд шатны хэмжлийн эталоноос гүйцэтгэнэ.

6.4.Хэмжлийн нэгжийг энэ хуулийн 7.2-т заасан аргачлалын дагуу холбогдох хэмжлийн эталон, хэмжих хэрэгсэлд дамжуулна.

7 дугаар зүйл.Хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлал

7.1.Хэмжлийг стандарт, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

7.2.Хэмжил гүйцэтгэх байгууллага өөрийн үйл ажиллагаанд хэрэглэх хэмжил гүйцэтгэх аргачлалыг боловсруулж, батална.

7.3.Хэмжих хэрэгсэл нь стандартын, хэмжил зүйн, техникийн болон ашиглалтын шаардлагыг хангасан байна.

7.4.Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдсэн, баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийг ашиглан хэмжил гүйцэтгэнэ.

7.5.Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл нь хэмжлийн үр дүнд нөлөөлөхөөс сэргийлсэн хийц, битүүмжлэлтэй байна.



7.6.Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэлд тавих тусгай шаардлагыг техникийн зохицуулалтаар тогтооно.

7.7.Энэ хуулийн 7.6-д заасан техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

8 дугаар зүйл.Хэмжил зүйн хяналт шалгалт, хамрах хүрээ, хэлбэр

8.1.Дараах үйл ажиллагаанд хэрэглэх хэмжил, хэмжих хэрэгсэл, хэмжил гүйцэтгэх аргачлалыг хэмжил зүйн хяналт шалгалтад хамруулна:

- 8.1.1.хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ;
- 8.1.2.аюулгүй байдлыг хангах;
- 8.1.3.байгаль орчныг хамгаалах;
- 8.1.4.улсыг батлан хамгаалах;
- 8.1.5.худалдаа, үйлчилгээний тооцоо.

8.2.Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах үйл ажиллагаа дараах хэлбэртэй байна:

- 8.2.1.хэмжих хэрэгслийн загварыг турших;
- 8.2.2.хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах;
- 8.2.3.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, бүртгэх.

8.3.Хэмжил зүйн төрийн хяналт дараах төрлөөс бүрдэнэ:

8.3.1.хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

8.3.2.савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт шалгалт хийх.

9 дүгээр зүйл.Хэмжих хэрэгслийн загварын туршилт

9.1.Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг загварын туршилтад хамруулна.

9.2.Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг хэмжил зүйн хүрээлэн гүйцэтгэнэ.

9.3.Энэ хуулийн 8.1.1-8.1.4-т заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн загварын туршилтыг хэмжил зүйн мэргэжлийн байгууллага холбогдох салбарын хүрээнд гүйцэтгэж болно.



9.4. Загварын туршилтад тэнцсэн, эсхүл загварын туршилтын үр дүнг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хэмжих хэрэгслийг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэж, загварыг баталсан гэрчилгээ олгоно.

9.5. Хэмжих хэрэгслийн загварын туршилтыг холбогдох стандарт болон энэ хуулийн 9.6-д заасан журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

9.6. Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журам, загварын туршилтын үр дүнг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

9.7. Импортлох хэмжих хэрэгсэлд дараах байгууллагаас загварыг баталж, гэрчилгээ олгосон тохиолдолд загварын туршилтыг давтан хийхгүйгээр хүлээн зөвшөөрнө:

9.7.1. Хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага /OIML/;

9.7.2. Энэ хуулийн 9.7.1-д заасан байгууллагаас эрх авсан хэмжил зүйн байгууллага, үйлдвэрлэгч;

9.7.3. Энэ хуулийн 19.1-д заасан байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулсан гадаад орны хэмжил зүйн төв байгууллага.

10 дугаар зүйл. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт

10.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортолсон, суурилуулсан, засварласны дараа, ашиглахын өмнө шалгалт баталгаажуулалтад хамруулна.

10.2. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага эрхэлнэ.

10.3. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага энэ хуулийн 8.1.1-8.1.4-т заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг холбогдох салбарын хүрээнд гүйцэтгэж болно.

10.4. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтыг улсын шалгагчийн эрх авсан ажилтан холбогдох стандартын дагуу гүйцэтгэнэ.

10.5. Баталгаажуулалтад тэнцсэн хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалт хийсэн байгууллага лац, тэмдгээр битүүмжилж, гэрчилгээ олгоно.

10.6. Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын лац, тэмдэг, гэрчилгээ, мэдэгдлийн загварыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

10.7.Шалгалт баталгаажуулалтын лац, тэмдэг нь хөндөгдсөн, арилсан, гэрчилгээг үрэгдүүлсэн, хуурамчаар үйлдсэн, баталгааны хугацаа дууссан, эвдэрсэн буюу буруу заалттай хэмжих хэрэгслийг баталгаагүйд тооцно.

10.8.Энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд баталгаажуулаагүй хэмжих хэрэгслийг худалдах, ашиглахыг хориглоно.

10.9.Загварын туршилтад хамрагдаж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэгдээгүй хэмжих хэрэгслийг шалгалт баталгаажуулалтад хамруулахгүй.

10.10.Хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хоорондын хугацааг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

10.11.Хэмжил зүйн олон улсын байгууллага болон үйлдвэрлэгч орны хэмжил зүйн байгууллагаас хэмжих хэрэгслийн анхдагч баталгаажуулалт хийх эрх авсан, олон улсын итгэмжлэлийн тогтолцооны дагуу итгэмжлэгдсэн үйлдвэрлэгчийн хэмжих хэрэгслийн анхдагч баталгаажуулалтын үр дүнг тэдгээртэй байгуулсан гэрээний үндсэн дээр харилцан хүлээн зөвшөөрч болно.

10.12.Хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх журмыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

11 дүгээр зүйл.Хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлэх, бүртгэх

11.1.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын чадавхыг үнэлж, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, тэдгээрийн чадавхыг үнэлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэх журмыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

12 дугаар зүйл.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний хэмжил зүйн хяналт, шалгалт

12.1.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээний утга холбогдох стандарт, дүрэм, журамд заасан хэмжил зүйн шаардлагыг хангасан байна.



12.2.Савласан бүтээгдэхүүний сав, баглаа боодол, шошго стандартын шаардлага хангасан байна.

12.3.Савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт, шалгалт хийх журмыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

13 дугаар зүйл.Хэмжил зүйн төрийн хяналт

13.1.Хэмжил зүйн төрийн хяналтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн² 9 дүгээр зүйлд заасан байгууллага хэрэгжүүлнэ.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан байгууллага Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-д зааснаас гадна дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

13.2.1.хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

13.2.2.хэмжлийн нэгж нь зөвшөөрөгдсөн нэгжтэй тохирч байгаа эсэхэд хяналт тавих;

13.2.3.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаанд хяналт тавих;

13.2.4.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг загварын туршилт, шалгалт баталгаажуулалтад хамруулсан эсэх, түүний ашиглалт, хэвийн ажиллагаанд хяналт тавих;

13.2.5.савласан бүтээгдэхүүний тоон хэмжээнд хэмжил зүйн хяналт тавих.

13.3.Энэ хуулийн 13.2.1-13.2.5-д заасан хэмжил зүйн хяналтыг хэрэгжүүлэх улсын байцаагч хэмжил зүйн чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

13.4.Хэмжил зүйн төрийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэмжил зүйн хяналтын үр дүнг энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан Зөвлөлд жил бүр тайлагнана.

14 дүгээр зүйл.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга

14.1.Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулж болно.

²Төрийн хяналт шалгалтын тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.



14.2.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг энэ хуулийн 19.2.4-т заасан журмын дагуу чадавхаа үнэлүүлсэн шалгалт тохируулгын ажилтан гүйцэтгэнэ.

14.3.Шалгалт тохируулгын лаборатори хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга гүйцэтгэх аргачлалтай байна.

14.4.Шалгалт тохируулгын лаборатори шалгалт тохируулга хийсэн хэмжих хэрэгсэлдээ гэрчилгээ олгож, тэмдэг дарна.

14.5.Хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгын лаборатори итгэмжлэгдсэн байна.

14.6.Хэмжил зүйн олон улсын байгууллагатай харилцан хүлээн зөвшөөрөх гэрээнд нэгдэн орсон гадаад орны хэмжил зүйн байгууллагын шалгалт тохируулгын гэрчилгээ, үр дүнг хүлээн зөвшөөрнө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХЭМЖИЛ ЗҮЙН БОДЛОГО, ХЭМЖИЛ ЗҮЙН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, БҮРЭН ЭРХ

15 дугаар зүйл.Хэмжил зүйн бодлого

15.1.Хэмжил зүйн бодлого нь улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, хүн, малын эрүүл мэнд, байгаль орчин, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, худалдаан дахь техникийн саад тотгорыг багасгахад чиглэсэн хэмжил зүйн тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэхэд оршино.

15.2.Хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг Засгийн газар батална.

16 дугаар зүйл.Хэмжил зүйн байгууллагын тогтолцоо

16.1.Хэмжил зүйн байгууллагын тогтолцоо нь Хэмжил зүйн зөвлөл, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага, хэмжил зүйн мэргэжлийн байгууллагаас бүрдэнэ.

17 дугаар зүйл.Засгийн газрын гишүүний бүрэн эрх

17.1.Засгийн газрын гишүүн эрхэлсэн асуудлын хүрээнд хэмжил зүйн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1.хэмжлийн эталоныг бий болгох, хөгжүүлэх;

17.1.2.техникийн зохицуулалт, стандарт боловсруулах, дүрэм, журмыг батлах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.



17.2.Шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих хэрэгслийн жагсаалтыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

18 дугаар зүйл.Хэмжил зүйн зөвлөл

18.1.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд хэмжил зүйг хөгжүүлэх, хэмжил зүйн бодлогыг хэрэгжүүлэх, салбар хоорондын уялдааг хангах үүрэг бүхий орон тооны бус Хэмжил зүйн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ төр, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагын төлөөлөлтэй ажиллана.

18.2.Зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

18.3.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга Зөвлөлийн хуралдааныг даргална.

18.4.Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.4.1.хэмжил зүйн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийн явцыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

18.4.2.Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлаар болон шийдвэрийн биелэлтийн талаарх судалгаа, мэдээг холбогдох байгууллага, албан тушаалтнаар гаргуулах;

18.4.3.хэмжил зүйн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар чиглэл, зөвлөмж өгөх;

18.4.4.энэ хуулийн 13.4-т заасан тайланг хэлэлцэх;

18.4.5.Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.

19 дүгээр зүйл.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

19.1.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хэмжил зүйн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах хэмжил зүйн төв байгууллага мөн.

19.2.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.2.1.хэмжил зүйн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

19.2.2.хэмжил зүйн дүрэм, журам баталж, хэрэгжилтийг хангах;

19.2.3.хэмжлийн эталоныг хөгжүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх;

19.2.4.хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын болон хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга хийх ажилтны чадавхыг үнэлэх журмыг баталж, хэрэгжилтийг хангах;

19.2.5.холбогдох төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын эрх олгох;

19.2.6.хариуцсан асуудлаар олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улс, бүс нутаг, гадаад улс орны хэмжил зүйн байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хэмжлийн үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх ажлыг зохион байгуулах;

19.2.7.хэмжил зүйн асуудлаар төлбөртэй ажил, үйлчилгээ эрхлэх, сургалт явуулах;

19.2.8.улсын шалгагчийн эрх олгох, аттестатчилах;

19.2.9.хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санг хөтлөх.

19.3.Хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэмжил зүйн хүрээлэнтэй байна.

19.4.Хэмжил зүйн хүрээлэн дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.4.1.улсын эталон, стандартчилсан загварыг бий болгох, зохион бүтээх, хадгалах, харьцуулан дүйлгэж баталгаажуулах;

19.4.2.хэмжил зүйн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил, туршилт хийх;

19.4.3.улсын эталоны нэгж дамжуулалтыг олон улсад болон үндэсний хэмжээнд хангах;

19.4.4.өндөр нарийвчлалтай хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх;

19.4.5.хэмжих хэрэгслийн загварын туршилт хийх;

19.4.6.үндэсний болон олон улсын хэмжлийн харьцуулалтад оролцох, зохион байгуулах;

19.4.7.хэмжил, шалгалт тохируулгын чадавхыг Жин, хэмжүүрийн олон улсын байгууллагын мэдээллийн санд бүртгүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх.

19.5.Улсын эталоныг хөтлөх, нэгж дамжуулах аргачлалыг хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.



20 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага

20.1. Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага харьяалах нутаг дэвсгэртээ хэмжлийн нэгдмэл байдлыг хангах чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.1.1. хэмжил зүйн хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

20.1.2. ажлын эталоныг бий болгох, хадгалах, ашиглах, тэдгээрийн нэгж дамжуулалтыг хангах;

20.1.3. хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх;

20.1.4. хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга хийх.

20.2. Аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд³ заасны дагуу сонгон шалгаруулж, аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

21 дүгээр зүйл. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага

21.1. Хэмжил зүйн мэргэжлийн байгууллага энэ хуулийн 22 дугаар зүйлд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлж болно:

21.1.1. энэ хуулийн 8.1.1-8.1.4-т заасан үйл ажиллагаанд хэрэглэх, холбогдох салбарын хүрээний хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэх;

21.1.2. тухайн хэмжлийн төрлөөр улсын болон ажлын эталоныг бий болгох, стандартчилсан загвар зохион бүтээх, хадгалах, нэгж дамжуулалтыг хангах.

ТАВДУГААР БҮЛЭГ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

22 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн хэмжил зүйн үйл ажиллагаа

22.1. Аж ахуйн нэгж, байгууллага, эрхэлсэн ажил, үйлчилгээнийхээ хүрээнд хэмжил зүйн чиглэлээр дараах эрх, үүрэгтэй:

22.1.1. хэмжил зүйн ажлыг тодорхой нэгж, албан тушаалтанд хариуцуулах, эсхүл хэмжил зүйн албыг ажиллуулах;

³Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/ Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

22.1.2.хэмжлийн шаардагдах нарийвчлал, хязгаарт тохирсон хэмжих хэрэгслийг ашиглах;

22.1.3.энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагаанд хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлсэн хэмжих хэрэгслийг хэрэглэх, үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах;

22.1.4.байгалийн нөөцийн олборлолт, ашиглалт, худалдаа, үйлчилгээний тооцоог шалгалт баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслээр гүйцэтгэх;

22.1.5.энэ хуулийн 8.1-д зааснаас бусад үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга хийх;

22.1.6.гүйцэтгэсэн хэмжлийн үр дүнгийн үнэн зөв байдлыг хариуцах;

22.1.7.хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, суурилуулах, засварлах үйл ажиллагаа эрхлэх бол чадавхаа үнэлүүлэх, хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлэх;

22.1.8.энэ хуулийн 12.1, 12.2-т заасан шаардлагыг хангасан савласан бүтээгдэхүүний тоон хэмжээ, зөвшөөрөх хэлбэлзлийн утгыг сав, баглаа боодлын шошгонд үндэсний стандартын дагуу тэмдэглэх;

22.1.9.хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт болон бусад ажил, үйлчилгээний зардлыг бүрэн хариуцах.

22.2.Аж ахуйн нэгж, байгууллага хэмжил зүйн дотоод хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

22.2.1.хэмжих хэрэгслийг загварын туршилт, шалгалт баталгаажуулалтад хугацаанд нь бүрэн хамруулж байгаа эсэхэд хяналт тавих;

22.2.2.өөрийн хэмжих хэрэгслийг шалгалт тохируулгад хамруулах;

22.2.3.хэмжих хэрэгслийн техникийн бэлэн байдал, ашиглалтад болон хэмжил гүйцэтгэх аргачлал, хэмжлийн шаардагдах нарийвчлал, хэмжил зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах.

22.3.Иргэн, төрийн бус байгууллага хэмжил зүйн чиглэлээр дараах эрх, үүрэгтэй:

22.3.1.хэмжих хэрэгсэлд шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт, хэмжил зүйн хяналт шалгалт хийлгэх хүсэлт гаргах;



22.3.2. хэмжил зүйн ажил, үйлчилгээ, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалтын талаар мэдээлэл авах;

22.3.3. хэмжих хэрэгслийн ашиглалт, хэмжил гүйцэтгэх аргачлал, хэмжих хэрэгслийн шалгалт баталгаажуулалтын явцад гарсан зөрчлийг эрх бүхий байгууллагад мэдээлэх, гарсан зөрчлийг арилгах талаар шаардах, шийдвэрлүүлэх;

22.3.4. хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалтын үйл ажиллагаанд ажиглагчаар оролцох, энэ талаар санал, хүсэлт гаргах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД

23 дугаар зүйл. Хэмжил зүйн үйл ажиллагааны санхүүжилт

23.1. Хэмжил зүйн зөвлөл, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн хэмжил зүйн байгууллага болон хэмжил зүйн мэргэжлийн байгууллагын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

23.2. Хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Төсвийн тухай хуульд⁴ заасны дагуу төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг хэмжил зүйн салбарыг бэхжүүлэх арга хэмжээнд зарцуулна.

23.3. Хэмжил зүйн олон улсын байгууллагын гишүүний татварыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

23.4. Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг хэмжил зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

24 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

24.1. Хэмжил зүйн хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд, хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд⁵ заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

⁴Төсвийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2011 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁵Зөрчлийн тухай хууль Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.24 дүгээр зүйлийн гарчгийг “Хэмжил зүйн тухай хууль зөрчих” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл баталгаажуулалтад хамрагдаагүй, эсхүл ашиглалт, суурилуулалтын шаардлага хангаагүй хэмжих хэрэгслийг ашигласан” гэснийг “Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй, эсхүл баталсан загвартаа тохирохгүй, эсхүл баталгаажуулалтад хамрагдаагүй, эсхүл ашиглах, суурилуулах шаардлага хангаагүй хэмжих хэрэгслийг хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд болон худалдаа, үйлчилгээнд ашигласан” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөлгүйгээр, эсхүл улсын бүртгэлд бүртгэгдээгүй, баталгаажуулалтад хамрагдаагүй хэмжих хэрэгслийг үйлдвэрлэсэн, худалдсан, эсхүл суурилуулсан, эсхүл засварласан” гэснийг “Хүн, мал эмнэлгийн оношилгоо, эмчилгээ, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд болон худалдаа, үйлчилгээний зориулалтаар ашиглах хэмжих хэрэгслийг хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгүүлэхгүйгээр импортолсон, үйлдвэрлэсэн, засварласан, суурилуулсан, эсхүл баталгаажуулалтад хамруулаагүй хэмжих хэрэгслийг худалдсан” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Хэмжил зүйн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХЭМЖИЛ ЗҮЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хэмжих хэрэгслийн загварын туршилт, шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулгын ажлыг 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.



2 дугаар зүйл. 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр баталсан Хэмжил зүйн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу олгосон хэмжих хэрэгслийг үйлдвэрлэх, суурилуулах, засварлах, худалдах тусгай зөвшөөрөл нь зөвшөөрөлд заасан хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд уг тусгай зөвшөөрлийг эзэмшигч хуулийн этгээдийг Хэмжил зүйн мэдээллийн улсын нэгдсэн санд бүртгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 1994 оны 12 дугаар сарын 22-ны өдөр баталсан Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ЗАРИМ ЗҮЙЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.17 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 05 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” гэснийг “Хэмжил зүйн тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хэмжил зүйн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 06 дугаар
сарын 07-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах бүлэг, хэсэг нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг:

“10.4.Гишүүн энэ хуулийн 4.9-д заасан хүндэтгэх шалтгаанаар хуралдаанд ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж чөлөө авна. Энэ тухай хуралдаан даргалагч танилцуулна.”

2/15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг:

“15.6.Түр хорооны даргыг энэ хуулийн 15.1-15.4-т заасан журмын дагуу сонгоно.”

3/15'дүгээр зүйлийн 15'1.4 дэх хэсэг:

“15'1.4.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зөвхөн Улсын Их Хурлын гишүүн санаачлах эрхтэй.”

4/20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг:

“20.3.Хуульд өөрчлөлт оруулах тухай төслийг хэлэлцэхдээ дараах санал, дүгнэлт гаргахыг хориглоно:

20.3.1.хууль санаачлагчийн өргөн мэдүүлээгүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт өөрчлөлт оруулах;

20.3.2.төсөлд тусгагдаагүй зүйлд өөрчлөлт оруулах;

20.3.3.төсөлд тусгагдаагүй хэсэгт өөрчлөлт оруулах;

20.3.4.төсөлд тусгагдаагүй заалтад өөрчлөлт оруулах;

20.3.5.төсөлд зүйл, хэсэг, заалт нэмэх;

20.3.6.төсөлд эшилсэн зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт

оруулах.”

5/21 дүгээр зүйлийн 21.19 дэх хэсэг:

“21.19.Төслийн нэг зүйл, хэсэг, заалтын талаар хоёр буюу түүнээс дээш саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа зэрэгцээ саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож санал хураалт явуулахгүй.”

6/23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг:

“23.8.Энэ хуулийн 23.7-д заасны дагуу боловсруулсан төслийг хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн төсөл гэж үзнэ.”

7/Гурав¹ дүгээр бүлэг:

“ГУРАВ¹ ДҮГЭЭР БҮЛЭГ

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэх журам

24¹ дүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх

24¹.1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /цаашид “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл” гэх/-ийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль¹ болон энэ хуульд заасан журмаар хэлэлцэнэ.

24¹.2. Байнгын хорооны хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний олонхи хүрэлцэн ирсэн бол түүнийг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр ирцтэй гэж үзнэ.

24¹.3. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд энэ хуулийн 4.1, 4.3 дахь хэсэг хамаарахгүй.

24¹.4. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүний асуулт асуух хугацаа 8 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, гишүүний асуултад хариулах хугацаа 8 минутаас илүүгүй, нэмэлт хариулт, тайлбар өгөх хугацаа 2 минутаас илүүгүй, гишүүн үг хэлэх хугацаа 10 минутаас илүүгүй, Байнгын хороо, нам, эвслийн бүлэг санал, дүгнэлтээ танилцуулах хугацаа 20 минутаас илүүгүй байна.

¹Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 3 дугаарт нийтлэгдсэн.



24^{1.5}.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.5 дахь заалтад заасны дагуу нууцаар санал хураахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна.

24^{1.6}.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээллийг нийтэд зарлан мэдээлэх, төслийг нийтэлж санал авах, түүнийг нэгтгэн судлах, хэлэлцүүлгийн явцад ирсэн саналыг нэгтгэн танилцуулах үйл ажиллагааг Төрийн байгуулалтын байнгын хороо, Тамгын газар хариуцан зохион байгуулна.

24^{1.7}.Хуулиар Улсын Их Хурлаас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн дундуур хэлэлцэн шийдвэрлэж болно.

24² дугаар зүйл.Нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэх

24^{2.1}.Төрийн байгуулалтын байнгын хороо Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

24^{2.2}.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэлийг сонсоно.

24^{2.3}.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болох бөгөөд хэлэлцэх эсэх асуудлаар цөөнх болсон гишүүн нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

24^{2.4}.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар уг төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх талаар санал, дүгнэлт гаргаж, түүнийг илтгэх гишүүнийг томилно.

24³ дугаар зүйл.Нэг дэх хэлэлцүүлэг явуулах

24^{3.1}.Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлнэ.

24^{3.2}.Нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн

12.2 дахь хэсэгт заасны дагуу гишүүд дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно.

24³.3.Төрийн байгуулалтын байнгын хороо санал гаргасан бол төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүдийн олонхийн саналаар байгуулна.

24⁴ дүгээр зүйл.Хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх

24⁴.1.Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлтээ гаргана.

24⁴.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, саналаа урьдчилан бичгээр томъёолж хуралдаан даргалагчид өгсний үндсэн дээр түүнийхээ үндэслэлийг тайлбарлан 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж санал хураалгах эрхтэй. Гишүүн хуралдаанд өөрөө оролцоогүй ч гэсэн гаргасан саналыг нь хэлэлцэж санал хураалт явуулна.

24⁴.3.Энэ хуулийн 24⁴.2-т заасан санал нь Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлан үг хэлж, санал хураалгах хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

24⁴.4.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед түүнд харьяалагдсан гишүүд таслах эрхтэй оролцоно.

24⁴.5.Саналын нэг томъёолоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны дэмжсэн санал гэж тооцон нэгдсэн хуралдаанд оруулна.

24⁴.6.Байнгын хороо санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгана:

24⁴.6.1.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх мэдээлэл;

24⁴.6.2.Байнгын хороо дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол, үндэслэл, шаардлага;



24⁴.6.3.санал хураалтын дүн.

24⁴.7.Байнгын хороод санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

24⁴.8.Төрийн байгуулалтын байнгын хороо холбогдох Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын үндэслэлийг санал тус бүрээр 5 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлан санал хураалгах бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг нэгдсэн хуралдаанд оруулна.

24⁴.9.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд тусгах шаардлагагүй санал гэж үзсэн үндэслэл, шалтгаанаа Байнгын хороо санал, дүгнэлтдээ тусгана.

24⁴.10.Зарчмын зөрүүтэй саналаар санал хураахдаа төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр хамтатган санал хураана.

24⁴.11.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах тухай санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар санал, дүгнэлт гаргана.

24⁴.12.Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт заасан Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.

24⁵ дугаар зүйл.Хоёр дахь хэлэлцүүлэг явуулах

24⁵.1.Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журмын дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

24⁵.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн болон эсрэг байр суурьтай гишүүн тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа санал хураалт явуулна.

24⁵.3.Нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэгт заасныг баримтлан шаардлагатай бол саналын нэг томъёоллоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг дэмжигдсэн санал гэж үзнэ.

24⁵.4.Энэхуулийн24⁵.3-т заасан санал хураалтаар шийдвэрлэгдсэн санал нь Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтын утга агуулга, ач холбогдлыг алдагдуулах, зөрчилдөхөд хүргэвэл Төрийн байгуулалтын байнгын хороо гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ өргөн мэдүүлсэн төслийн зүйл, хэсэг, заалтыг баримтлан зөрчлийг арилгах санал, дүгнэлт гаргана.

24⁶ дугаар зүйл.Гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх

24⁶.1.Төрийн байгуулалтын байнгын хороо дараах журмаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэнэ:

24⁶.1.1.нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нэмж тусган эцсийн хувилбар болон гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал, дүгнэлт гаргах;

24⁶.1.2.энэ хуулийн 24⁶.1.1-д заасан Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, санал, дүгнэлтийг Байнгын хорооны гишүүдэд гурваас доошгүй хоногийн өмнө урьдчилан тарааж, хуралдаанаар хэлэлцэх;

24⁶.1.3.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийх саналын томъёоллыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэж, шийдвэрлэх;

24⁶.1.4.энэ хуулийн 24⁵.4-т заасан зөрчлийг арилгах зорилгоор Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтыг баримтлан санал хураалт явуулах бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгана.

24⁶.2.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд



тусгах шаардлагагүй гэж үзсэн үндэслэл, шалтгаанаа Байнгын хороо санал, дүгнэлтдээ тусгана.

24⁶.3.Энэ хуулийн 24⁶.1.3, 24⁶.1.4-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно.

24⁷ дугаар зүйл.Гурав дахь хэлэлцүүлэг явуулах

24⁷.1.Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан журмын дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

24⁷.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонссоны дараа гишүүд зөвхөн Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж болно.

24⁷.3.Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ хуулийн 24⁵.4-т заасан зөрчлийг арилгах санал болон төслийн зүйл, хэсэг, заалтад найруулга хийсэн бол саналын томъёолол тус бүрийг 10 минутад багтаан тайлбарлаж, саналын томъёолол бүрийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай гишүүд тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж болно.

24⁷.4.Саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй нь дэмжсэн бол саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгана.

24⁷.5.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсэгт заасан санал хураалтыг хоёр удаа явуулахад нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно.

24⁷.6.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг энэ хуулийн 21-24 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн баталж болно.

24⁸ дугаар зүйл. Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх

24⁸.1. Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Ард нийтийн санал асуулгын тухай хууль², Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэнэ.

24⁸.2. Төрийн байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар Ард нийтийн санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж, Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар батална.

24⁸.3. Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын гишүүн, цөөнх хоёр дахь хэлэлцүүлгээр батлагдсан саналаасаа зөрүүтэй болон өөр зүйл, хэсэг, заалт нэмэх санал гаргахыг тус тус хориглоно.

24⁸.4. Төрийн байгуулалтын байнгын хороо ард нийтийн санал асуулгад оруулах төслийг дараах журмаар нэгдсэн хуралдааны нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэнэ:

24⁸.4.1. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган ард нийтийн санал асуулгад оруулах төсөл болон нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал, дүгнэлт гаргах;

24⁸.4.2. энэ хуулийн 24⁸.4.1-д заасан төсөл, санал, дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх;

24⁸.4.3. ард нийтийн санал асуулгад оруулах төсөлд найруулгын засвар хийх саналын томъёоллыг Байнгын хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэн шийдвэрлэх.

² Ард нийтийн санал асуулгын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 9 дүгээрт нийтлэгдсэн.



24⁸.5. Нэгдсэн хуралдаанаар ард нийтийн санал асуулгад оруулах төслийн нэг дэх хэлэлцүүлгийг дараах журмаар явуулна:

24⁸.5.1. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсох;

24⁸.5.2. санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, тайлбар авах;

24⁸.5.3. Төрийн байгуулалтын байнгын хорооноос Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийсэн бол найруулгын томъёолол тус бүрийг 10 минутад багтаан тайлбарлаж, найруулгын томъёолол бүрийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай гишүүн тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх;

24⁸.5.4. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийх саналын томъёолол тус бүрийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэж, шийдвэрлэх;

24⁸.5.5. ард нийтийн санал асуулгад оруулах төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэх.

24⁸.6. Төрийн байгуулалтын байнгын хороо ард нийтийн санал асуулгад оруулах төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт дараах журмаар бэлтгэнэ:

24⁸.6.1. нэгдсэн хуралдааны нэг дэх хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн найруулгын томъёоллыг тусгасан ард нийтийн санал асуулгад оруулах төслийг бэлтгэх;

24⁸.6.2. гишүүд төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх;

24⁸.6.3. ард нийтийн санал асуулгад оруулах төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах талаар санал, дүгнэлт гаргах.

24⁸.7. Нэгдсэн хуралдаанаар ард нийтийн санал асуулгад оруулах төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дараах журмаар явуулна:

24⁸.7.1. Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсох;

24⁸.7.2.Улсын Их Хурлын гишүүд ард нийтийн санал асуулгад оруулах төсөлтэй холбогдуулан асуулт асууж, тайлбар авах, үг хэлэх;

24⁸.7.3.ард нийтийн санал асуулгад оруулах эхийг батлах.

24⁸.8.Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн саналаар ард нийтийн санал асуулгад оруулах эхийг батлах санал өгсөн бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно.

24⁹ дүгээр зүйл.Ард нийтийн санал асуулгын дүнг Улсын Их Хуралд танилцуулах

24⁹.1.Нэгдсэн хуралдаанаар ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэл, Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг сонсоно.

24⁹.2.Гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэл, Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

24⁹.3.Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуулийн эхийг сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцож, тэдгээрийн олонхи нь уг хуулийг “зөвшөөрнө” гэсэн санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанд тооцож, хуралдаан даргалагч зүйл, хэсэг, заалт нэг бүрээр уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болно.

24⁹.4.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуулийг хүчин төгөлдөр болсонд тооцсоноос хойш ажлын хоёр өдрийн дотор Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид биечлэн хүргэж танилцуулна.

24⁹.5.Ард нийтийн санал асуулгаар батлагдсан хуулийн уг эхийг нотлох, хадгалах, албан ёсны эхийг нийтлэхэд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсэгт заасныг баримтална.”

8/51⁴ дүгээр зүйлийн 51⁴.2 дахь хэсэг:

“51⁴.2.Нийтийн сонголыг зохион байгуулах ажлын хэсгийг Байнгын хорооны тогтоолоор байгуулж болно.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.1 дэх заалтын “саналыг”



гэсний дараа “тайлбарлаж болох бөгөөд түүнийг” гэж, 25 дугаар зүйлийн 25.13 дахь хэсгийн “энэ хуулийн 25.10-д заасан” гэсний дараа “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах” гэж, 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийн “асууж” гэсний дараа “, үг хэлж” гэж, 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийн “ажлынхаа тайлан” гэсний дараа “хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг:

“10.2.Гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг горимынх гэх бөгөөд түүгээр нэг удаа санал хураана. Энэ хуулийн 4.4-т заасны дагуу хэлэлцэх асуудалд ороогүй болон хуультай зөрчилдөх асуудлаар санал гаргасан бол санал хураалт явуулахыг хориглоно.”

2/20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг:

“20.2.Энэ хуулийн 20.1-т заасан төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөлтэй нийцүүлэх өөрчлөлтөд энэ хуулийн 20.3-т заасан хүрээ хязгаар хамаарахгүй.”

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “хэлэлцэнэ” гэснийг “зохион байгуулна” гэж, 16 дугаар зүйлийн 16.13 дахь хэсгийн “сонгоно” гэснийг “, ахлагчийг сонгож, томилсноор ажлын хэсэг байгуулах тухай тогтоол батлагдсанд тооцно” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь заалтын “төслийг” гэснийг “төслийн үзэл баримтлалыг” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн дугаарыг “20.4” гэж, 21 дүгээр зүйлийн 21.14 дэх хэсгийн “саналаа тайлбарлан санал хураалгаж” гэснийг “саналаа тайлбарлаж” гэж, 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсгийн “гишүүдийн” гэснийг “гишүүд, Ерөнхийлөгч, Төрийн аудитын төв байгууллагын” гэж, мөн зүйлийн 25.12 дахь хэсгийн “явуулна” гэснийг “явуулах бөгөөд саналуудыг багцалж хурааж болно” гэж, 36¹ дүгээр зүйлийн гарчгийн “Зохион байгуулалтын шинжтэй” гэснийг “Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хуульд тусгайлан заасан” гэж, 51² дугаар зүйлийн 51².3 дахь хэсгийн “мэргэжлийн шинжээч” гэснийг “шинжээч, ажиглагч” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтын “нэмэлт асуулт

асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд нэмэлт” гэснийг, 9¹ дүгээр зүйлийн 9^{1.2} дахь хэсгийн “асуулт асуух, үг хэлэх,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хүн тус бүрээр” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.3.4 дэх заалтын “үзэл баримтлалын” гэснийг, 36¹ дүгээр зүйлийн 36^{1.4} дэх хэсгийн “зохион байгуулалтын шинжтэй” гэснийг, 51⁴ дүгээр зүйлийн 51^{4.1} дэх хэсгийн “Энэ хуулийн 16.5-д заасан ажлын хэсгийн, эсхүл нийтийн сонголыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагч нь сонгол даргалагч байж болно.” гэсэн хоёр дахь өгүүлбэрийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийг, 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 2 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар
хот

Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 8.4, 8.5-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделханд даалгасугай.

3. “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улс, орон нутгийн төсөвт тусгах, гадаад, дотоодын зээл тусламжид хамруулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж ажиллахыг Барилга,



хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАДЕЛХАН

Засгийн газрын 2019 оны 70 дугаар
тогтоолын хавсралт

**ТӨРӨӨС БАРИЛГЫН САЛБАРЫН ТАЛААР
БАРИМТЛАХ БОДЛОГО**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан хот байгуулалтын нэгдсэн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалан орон нутгаас төв суурин газар руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн эрс нэмэгдэж, хот, суурин газруудад төлөвлөлтгүй, эмх замбараагүй суурьшил ихээр бий болж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах эрх хангагдахгүй, ашиг сонирхол нь зөрчигдөж байна.

Улсын эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал, хөгжлийн цаашдын чиг хандлагатай уялдуулан хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөлтөд нийцүүлэн барилгын салбарын бодлогод шинэчлэл хийх, олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Өнөөгийн байдлаар барилгын салбарын бүтээн байгуулалтын ажлын 94.4 хувийг хувийн хэвшил гүйцэтгэж, жилдээ нийт 3.566,0 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэх чадавх бүхий үндэсний компаниуд энэ салбарт ажиллаж байна.

Барилгын салбар зах зээлийн зарчмын дагуу хувийн хэвшлийн үйл ажиллагаанд тулгуурлан хөгждөг хэдий ч эрэлт, нийлүүлэлтийн нэгдсэн тооцоо, судалгаагүй, зах зээлийн эрсдэлийн үнэлгээ хийхгүйгээр үйл ажиллагаа явуулснаас өнөөгийн байдлаар барилгын салбарын хувьд 1.0 их наяд төгрөгийн хөрөнгө барьцаалсан 540 тэрбум орчим төгрөгийн зээлийн өртэй, үүний 318.4 тэрбум нь хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл болоод байна.

Орон сууц барих зориулалтаар 4.76 их наяд төгрөгийн зээл олгогдсон боловч иргэдийн орон сууц худалдан авах төлбөрийн чадвар

жил ирэх тусам буурч 1.9 их наяд төгрөгийн эргэн төлөгдөх баталгаагүй зээл хуримтлагдаж, зах зээлийн эдийн засгийн харилцааны хэвийн нөхцөл алдагдаж, барилгын салбарт төдийгүй банк, санхүүгийн салбарыг эрсдэлтэй нөхцөл байдалд хүргэж болзошгүй байна.

Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажил цахим хэлбэрт шилжиж, 2018 оны байдлаар энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 854 байгууллага, аж ахуйн нэгж салбарт ажиллаж байгаа хэдий ч зураг төслийг иж бүрнээр боловсруулдаг байгууллагуудын тоо цөөн байгаа нь зураг төслийн болон тооцоо, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэхэд дорвитой нөлөө үзүүлж чадахгүй байна.

Барилгын салбарт эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байхгүй, салбарын хөгжлийг шинжлэх ухааны үндэслэлтэй төлөвлөх, судалгаа шинжилгээний тэргүүлэх чиглэлүүд тодорхойгүй байгаагаас техник технологи, инновацийг хөгжүүлэх үйл ажиллагаа дутмаг байна. Барилгын салбарт 2018 оны байдлаар шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгө оруулалтаар 449.2 сая төгрөгийн 6 төсөл хэрэгжсэн нь салбарын хөгжилд бодитой нөлөө үзүүлж чадахгүй байна.

Импортыг орлох, дотооддоо үйлдвэрлэдэг барилгын материал, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо, чанарт жилээс жилд ахиц дэвшил гарч, үйлдвэрлэлийн хүчин чадал цементийн хувьд 6, бетон хийц, эдлэлийн хувьд 4, хөнгөн бетоны хувьд 2 дахин нэмэгдсэнээр барилгын гол, нэр төрлийн түгээмэл хэрэглэгддэг бетон, төмөр бетон болон барилгын дүүргэлтийн материал, хаших бүтээц, дулаалгын материалын хэрэгцээг 100 хувь дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшинд хүрсэн. Гэвч Улаанбаатар хот дахь барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн төвлөрлийг сааруулах зорилгоор барилгын материалын үйлдвэрүүдийг орон нутагт бүсчлэн байгуулах, уул уурхай, дэд бүтцийн салбарт хэрэгжих томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажил, эрэлт, хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэх, барилгад өргөнөөр хэрэглэгдэх гол нэр, төрлийн материал, бүтээгдэхүүнийг тодорхойлж, эрэлт, хэрэгцээний тэнцвэрт байдлыг хангах, дотоодын зах зээлийг хамгаалах замаар барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологи үйлдвэрлэлийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Барилгын материал, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт, түгээлт өртөг, зардал ихтэй үйлдвэрлэл, тээвэр ложистикийн тогтолцоонд суурилсан, эдийн засгийн хувьд үр ашиггүй байгаа тул захиалга хүргэлтийн үйлчилгээний оновчтой хэлбэрт шилжүүлэх шаардлага үүсээд байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний судалгааны дүнгээр 2018 оны байдлаар барилгын салбарт улсын хэмжээнд 59078 ажиллагсад



байгаа бөгөөд цаашид уг ажиллах хүчний хэмжээг 18.6 мянган хүнээр нэмэгдүүлэх хэрэгцээ байна.

Барилгын салбарын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиуд болон мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд 2018 оны байдлаар нийт 72 мэргэжлээр 1480 инженер, техникийн ажилтан, барилгын өргөн мэргэжлээр 13825 ажилчин сурган бэлтгэж, мэргэжил эзэмшүүлэн төгссөн байна. Гэсэн хэдий ч төгсөгчдийн мэдлэг, ур чадвар ажил олгогчоос тавьж байгаа шаардлагад нийцэхгүй, төгсөгчид мэргэжлээрээ ажиллахгүй байх зэрэг асуудал түгээмэл байна.

Барилгын салбарын техникийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх үндэс болсон барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг техник, технологийн өнөөгийн хурдацтай хөгжилтэй уялдуулан боловсронгуй болгох, олон улсын түвшинд ойртуулах, хүргэх зайлшгүй шаардлага үүсээд байна.

Орон сууц, олон нийт, үйлдвэрийн бүх төрлийн барилга байгууламжийг төлөвлөх, барих асуудлыг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас мэргэжлийн нэгдсэн бодлогоор хангаж, барилга байгууламжийн хүчин чадлыг хот төлөвлөлт, барилгажилтын бодлогод нийцүүлэн хүн амын тоо, суурьшилд тулгуурлан оновчтой төлөвлөж, хүн амыг орон сууцаар хангах, төвлөрлийг сааруулах, орчны бохирдлыг бууруулах болон хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна.

Улсын хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллагаанд төрийн оролцоог багасгах, хяналтыг хөндлөнгийн зөвлөх үйлчилгээгээр дамжуулан хэрэгжүүлэх, барилгын төслийн удирдлага, мэдээллийн нэгдсэн систем (БТУМНС)-д шилжүүлэх, олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ны барилгын гэрээг нэвтрүүлэх, барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, түгээлтийн одоогийн тогтолцоог өөрчлөх, төрөөс дотоодын зах зээлийг зохицуулах замаар салбарын эдийн засгийн дархлааг хамгаалах хэрэгцээ байна.

Хот байгуулалт, барилгын салбарын үйл ажиллагааны шинэчлэлийг гүнзгийрүүлж, салбарын техникийн нэгдсэн бодлого, инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж шинэ түвшинд гаргах, импортыг орлох экспортын баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжиж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, материал, бүтээгдэхүүн, техник, технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарал, эрчим хүчний хэрэглээ, дулаан алдагдлыг бууруулж, тогтвортой, ухаалаг, ногоон хот, ногоон барилгын үйл ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх арга замыг тодорхойлох шаардлагатай байна.

Хоёр. Бодлогын зорилго, зорилт

2.1. Бодлогын зорилго

Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогын зорилго нь бүс нутаг, хот байгуулалтын хөгжлийн чиг хандлага, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан барилгын салбарын хөгжлийг эрчимжүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

2.2. Бодлогын зорилтууд

2.2.1. салбарын бүтэц, тогтолцоог оновчтой тогтоох, хууль эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгох замаар барилгын техникийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж салбарын хөгжлийг эрчимжүүлэх;

2.2.2. салбарын шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох;

2.2.3. хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд суурилсан хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажилд тогтвортой, ухаалаг, ногоон хөгжлийн зарчмыг тусган олон улсын түвшинд хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлэх;

2.2.4. хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар барилгын салбарын эдийн засгийн өсөлтийг хангах;

2.2.5. эх орны эрдэс, түүхий эдийн нөөцийг үр ашигтай, зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын чиг баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх;

2.2.6. барилгын салбарын мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, шинэчлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлж, салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах арга хэмжээ авч зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;

2.2.7. орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн хангамж, чанар, үйлчилгээг нэмэгдүүлэх замаар иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах;



2.2.8. барилгын салбарыг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцэд тулгуурлан газрын харилцааны бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх.

2.3. Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.3.1. Салбарын бүтэц, тогтолцоог оновчтой тогтоох, хууль, эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгох замаар барилгын техникийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэн салбарын хөгжлийг эрчимжүүлэх чиглэлээр:

2.3.1.1. салбарын төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, чиг үүргийн давхардалгүй, цомхон, чадварлаг байхаар шинэчлэх;

2.3.1.2. хууль, эрх зүйн баримт бичгүүд хоорондын зөрчил, хийдэл, давхардлыг арилгаж, салбар дундын уялдаа, зохицуулалтыг сайжруулах;

2.3.1.3. салбарын норм, нормативын баримт бичгүүдийг эрдэм шинжилгээ, судалгаанд суурилан боловсронгуй болгон шинэчилж, олон улсын жишигт нийцүүлэх;

2.3.1.4. салбарын бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим сан бүрдүүлж, цахим засаглалыг төлөвшүүлэх;

2.3.1.5. олон улсад нийтлэг мөрдөгддөг гэрээ, стандартуудыг хэрэглэх, нэвтрүүлэх замаар барилгын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах;

2.3.1.6. барилгын салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахтай холбогдсон стандарт, норм, дүрэм, журмыг боловсронгуй болгох, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

2.3.2. Салбарын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох чиглэлээр:

2.3.2.1. эх орны эрдэс түүхий эдийг гүн боловсруулах, барилгын ажлын улирлын нөлөөллийг багасгах, инженер геологийн судалгааг нэмэгдүүлэх, газар хөдлөлт, үерийн гамшгийн эрсдэлийг бууруулах болон эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлэх судалгаа, шинжилгээг салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлэх;

2.3.2.2. шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хамтын ажиллагаанд суурилсан гарааны компани байгуулах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, бойжуулах, нутагшуулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх.

2.3.3. Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд суурилсан хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажилд тогтвортой, ухаалаг, ногоон хөгжлийн зарчмыг тусган олон улсын түвшинд хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр:

2.3.3.1. хот байгуулалт, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажлын төлөвлөлт, чанарыг сайжруулах замаар хүн амын шилжилт хөдөлгөөн, төвлөрлийг сааруулж, нийгмийн үйлчилгээний чанарт дэвшил гаргах;

2.3.3.2. хот байгуулалт, барилга байгууламжийн зураг төслийн байгууллага, мэргэжилтнүүдийн хариуцлагыг өндөржүүлж, ажлын уялдаа холбоог сайжруулах болон зураг төсөлд хийгдэх магадлалын хяналтыг боловсронгуй болгох;

2.3.4. Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар барилгын салбарын эдийн засгийн өсөлтийг хангах чиглэлээр:

2.3.4.1. салбарын хөгжлийн дунд ба урт хугацааны төлөвлөлтийг улсын хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлттэй уялдуулж, түүнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг хангах;

2.3.4.2. зах зээлийн харилцаанд нийцүүлэн үндэсний бүтээн байгуулалтын чадавхыг нэмэгдүүлэх, дэмжих, салбарын эдийн засгийн дархлааг бэхжүүлэх, хамгаалах;

2.3.4.3. эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгыг дэмжих хөнгөлөлттэй зээл, татвар, урамшууллын тогтвортой тогтолцоог бий болгох, хөгжүүлэх.

2.3.5. Эх орны эрдэс, түүхий эдийн нөөцийг үр ашигтай, зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын чиг баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх чиглэлээр:

2.3.5.1. барилгын материалын үйлдвэрлэлийн жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, үндсэн нэр, төрлийн материалаар дотоодын хэрэгцээг хангах;



2.3.5.2. барилгын материалын эрдэс түүхий эдийн хайгуул, судалгааг өргөжүүлэх, хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай технологи нэвтрүүлэх замаар материалын нэр төрөл, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх;

2.3.5.3. хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, эрчим хүчийг хэмнэх, хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах;

2.3.5.4. барилгын материал, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулах;

2.3.5.5. барилгын материал, бүтээгдэхүүний ханган нийлүүлэлтийн сүлжээ, тээвэр ложистикийг оновчтой, боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх.

2.3.6. Барилгын салбарын мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, шинэчлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлж, салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах арга хэмжээ авч зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр:

2.3.6.1. инженерийн болон мэргэжлийн сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлж, сургалт, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, мэргэжилтний мэргэжлийн чадамж, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх;

2.3.6.2. барилгын салбар дахь зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, ажлын байрны тогтвортой байдлыг хангаж хөдөлмөрийн зах зээлийг хамгаалах;

2.3.6.3. инженер, техникийн мэргэжилтнүүдийн мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх, мэргэшүүлэх, сургалтын болон үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох.

2.3.7. Орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн хангамж, чанар, үйлчилгээг нэмэгдүүлэх замаар иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр:

2.3.7.1. хот байгуулалтын бодлого, төлөвлөлтөд суурилсан орон сууцны үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэн зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх;

2.3.7.2. нийтийн аж ахуйн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох;

2.3.7.3. инженерийн дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр бүтээн байгуулалтын ажил өрнүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх.

2.3.8. Барилгын салбарыг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцэд тулгуурлан газрын харилцааны бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх чиглэлээр:

2.3.8.1. барилгын салбарыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг орон зайн мэдээлэлд тулгуурлан газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх.

Гурав. Бодлогыг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

3.1. Бодлогыг 2019-2029 онд дараахь үе шаттай хэрэгжүүлнэ:

I үе шат: 2019-2021 онд барилгын салбарын бодлого, үйл ажиллагаанд шинэчлэлт хийгдэж, хууль, эрх зүйн орчин боловсронгуй болсноор төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт цомхон, чадварлаг болж, төрийн зохицуулалт сайжирч, төр, хувийн хэвшлийн түншлэл өргөжих нөхцөл бүрдэнэ.

II үе шат: 2022-2025 онд барилгын төслийн удирдлага, мэдээллийн нэгдсэн цахим систем нэвтэрч, норм, нормативын баримт бичиг боловсронгуй болсноор барилгын үйл ажиллагааны уялдаа холбоо, чанар сайжирч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангагдах бодит нөхцөл бий болж, үндэсний бүтээн байгуулалтын чадавх нэмэгдэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, бизнесийн тогтвортой, таатай орчин нөхцөл бүрдэнэ.

III үе шат: 2026-2029 онд барилгын салбарын үйл ажиллагаа шинжлэх ухаан, инновацид суурилан хөгжих боломж нөхцөл бүрдэж, эрчим хүч, усны хэмнэлттэй, байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй, барилгын материал, бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэн барилгын ажил улирлын хамаарлаас гарна.

Дөрөв. Бодлогын үр нөлөө, бүтээгдэхүүний шалгуур үзүүлэлт

4.1. Бодлогын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дараахь байдлаар тогтоож, 2018 оны тоон мэдээллийг суурь үзүүлэлт болгон үнэлнэ:

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2018 он	Зорилтот түвшин		
					2021 он	2025 он	2029 он
1.	Салбарын бүтэц, тогтолцоог оновчтой тогтоох, хууль эрх зүйн орчин, норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох замаар барилгын техникийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж салбарын хөгжлийг эрчимжүүлнэ.	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	тоо	0	1	-	-
		Нэмэлт, өөрчлөлт оруулах хууль	тоо	-	6	11	-
		Техникийн зохицуулалт	тоо	-	1	2	3
		Норм, нормативын баримт бичгийн боловсруулалт	хувь	27	40	60	80
		Олон улсын жишигт нийцсэн стандарт	хувь	55	60	70	80
		Цахим сан, програм хангамж	тоо	1	2	4	-
		Нэгдсэн цахим систем	тоо	-	1	-	-
		Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001 стандарт нэвтрүүлэх байгууллага, аж ахуйн нэгж	тоо	9	12	25	50

		хувь	8	15	40	66
Барилгын үйл ажиллагааны олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ны барилгын гэрээний хэрэгжилт		хувь	-	3	10	15
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо MNS ISO 45001 стандарт нэвтрүүлэх байгууллага, аж ахуйн нэгж		хувь	-	100	100	100
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт		хувь	-	10	15	20
Импортыг орлох, экспортыг дэмжих шинэ материал, бүтээгдэхүүний судалгаа, үйлдвэрлэл		тоо	-	2	4	6
Барилга угсралтын ажлын улирлын нөлөөллийг бууруулах судалгаа, үйлдвэрлэл		тоо	-			
2. Салбарын шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, эрдэм шинжилгээ, судалгаанд суурилсан инновацийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоно.						

	Инженер геологийн болон инженерийн бэлтгэл ажлын судалгаа	Тоо	-	2	4	6
	Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй технологийн судалгаа, үйлдвэрлэл	Тоо	-	2	5	10
	Үйлдвэрлэл, технологийн парк	Тоо	-	1	1	-
	Ногоон барилгын технологи нэвтрүүлэх гарааны компани	Тоо	10	20	30	40
	Хот төлөвлөлийн норм, нормативын баримт бичиг	Тоо	-	2	4	6
	Ерөнхий төсөл, хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	хувь	-	-	10	20
3.	Хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцоонд суурилсан хот төлөвлөлтийг хэрэгжүүлэх, барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах ажилд тогтвортой, ухаалаг, ногоон хөгжлийн зарчмыг тусган олон улсын түвшинд хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Тоо	2	10	40	80
	Магадлалын үйл ажиллагаа	Үе шат	2	1	-	-

4.	Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар барилгын салбарын эдийн засгийн өсөлтийг хангана.	ДНБ-д эзлэх барилгын салбарын хувь хэмжээ	хувь	3.7	5	5	5
		Барилгын ажлын механикжилт	хувь	60.9	61	62	65
5.	Эх орны эрдэс, түүхий эдийн нөөцийг үр ашигтай, зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын чиг баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлнэ.	Барилга угсралтын ажлын хэмжээ	төгрөг (тэрбум)	2.944.6	4.343,0	8.338,0	12.330,0
		Ногоон барилгын үнэлгээний систем	Тоо	-	1	2	-
		Ногоон гэрчилгээтэй барилга	Тоо	-	5	10	20
		Үндсэн нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэлийн өсөлт	хувь	-	1.24	1.79	2.07
		Эрдэс хөвөнгийн үйлдвэрийн хүчин чадал	мян м. куб	15	20.2	29.1	31.6
		Гангийн үйлдвэрийн хүчин чадал	мян. тонн	100.0	150.0	235.0	435.0
		Дотоодын эрдэс түүхий эдийн ашиглалт	ордын Тоо	263	273	283	293

Шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэр	тоо	554	560	570	580
Барилгын дулаан алдагдлын бууралт	хувь	-	20	30	40
Барилгын салбарын хүлэмжийн хийн бууралт	мян.тн CO ₂	0.3	10.9	30.1	53.7
Тохирлын гэрчилгээтэй бүтээгдэхүүн	тоо	410	480	550	580
Лабораторийн хүчин чадлын өсөлт	дахин	-	1.5	2.5	3.0
Чөлөөт бүсэд байгуулах импортын хангамжийн төв	тоо	-	1	2	-
Бөөний худалдааны сүлжээ	тоо	-	1	1	1

	<p>Барилгын салбарын мэргэжлийн сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, шинэчлэх замаар сургалтын чанарыг дээшлүүлж, салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах арга хэмжээ авч зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</p>	<p>Олон улсын жишигт нийцсэн сургалтын хөтөлбөртэй их дээд сургууль</p> <p>Мэргэжлийн сургалтанд олгох тэтгэлэг</p> <p>Ажиллах хүчний хэрэгцээ</p> <p>Гадаад ажилчид</p> <p>Инженер, техникийн ажилтны сургалтад хамрагдах хувь хэмжээ</p> <p>Ур чадварын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт</p> <p>Орон сууцны үндэсний хөтөлбөр</p>	<p>Тоо</p> <p>хувь</p> <p>Мян.хүн</p> <p>хувь</p> <p>хувь</p> <p>хувь</p> <p>Тоо</p>	<p>-</p> <p>-</p> <p>65.0</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p> <p>-</p>	<p>5</p> <p>40</p> <p>70.2</p> <p>9.3</p> <p>20.0</p> <p>20.0</p> <p>1</p>	<p>10</p> <p>60</p> <p>76.0</p> <p>9</p> <p>40.0</p> <p>40.0</p> <p>-</p>	<p>15</p> <p>100</p> <p>85.0</p> <p>8</p> <p>60.0</p> <p>60.0</p> <p>-</p>
6.		<p>Орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн хангамж чанар, үйлчилгээг нэмэгдүүлэх замаар иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулна.</p>	<p>Тоо</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>-</p>	<p>-</p>
7.		<p>Төрөөс нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичиг</p>	<p>Тоо</p>	<p>-</p>	<p>1</p>	<p>-</p>	<p>-</p>
8.		<p>Төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр</p>	<p>Тоо</p>	<p>-</p>	<p>3</p>	<p>-</p>	<p>-</p>



Тав. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр

5.1. Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
- 5.1.2. гадаадын зээл, тусламж;
- 5.1.3. гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 5.1.4. бусад эх үүсвэр.

Зургаа. Бодлогын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1. Бодлогын хэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хийж, дөрвөн жил тутам хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.75

Индекс: 200003